



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН  
ХОРШООДЫН  
2020 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР  
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР**

**УЛААНБААТАР ХОТ**

# АГУУЛГА

<b>НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	2
1.1 ХЗХ-ны салбарын ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	4
1.4 Хууль тогтоомжийн өөрчлөлт.....	5
<b>ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b> .....	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
<b>ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	10
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	10
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	11
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	13
<b>ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР</b> .....	14
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	14
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	15
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	16
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	17
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	17
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	17
<b>ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА</b> .....	18
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	18
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	18
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	19
5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	19
5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	20
<b>ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР</b> .....	20
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	20
6.2 Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	21
6.3 Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	22
<b>ДОЛОО.ДҮГНЭЛТ</b> .....	23

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021.02.05


Улаанбаатар хот

## НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 ХЗХ-ны салбарын ерөнхий мэдээлэл

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 249 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 ХЗХ буюу 4.6 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 40.6 хувь буюу 101 ХЗХ орон нутагт, 59.4 хувь буюу 148 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо, хот, орон нутгаар




Тайлант улиралд Хорооны хуралдаанаар шинээр 3 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 7 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 2 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг тус тус шийдвэрлэсэн байна. Мөн 2020 оны 4 дүгээр улиралд 1 ХЗХ-ны сонгуульт гишүүд, 1 ХЗХ-ны ажлын байрны хаягийн

өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2016	2017	2018	2019	2020.IV
ХЗХ-дын тоо	280	290	279	261	249
Шинээр олгосон	34	17 /1/	18	17	14
Хүчингүй болгосон	7	8	29	35	26
Түдгэлзүүлсэн	2	21	19	10	23
Сэргээсэн	-	4	7	1	6
ТЗ-ийн хугацаа сунгасан	48	54	100	52	49

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа




## 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 249 ХЗХ 61 салбар, 841 ажилтан, 72,651 гишүүн /72,439 иргэн, 212 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.


Улаанбаатар хотын 9 дүүрэгт 148 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 ХЗХ буюу 9.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 101 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 ХЗХ буюу 4.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Баян-Өлгий, Орхон, Увс, Говь-Алтай, Ховд аймгуудад ХЗХ-д ихээр төвлөрсөн байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



Тайлант улирлын байдлаар нийт 7 ХЗХ 61 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. Салбарын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 салбар буюу 12.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 3 ХЗХ-ны 54 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

### 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,683 гишүүн буюу 2.4 хувиар нэмэгдэж 72,651-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 212 хуулийн этгээд, 53.7 хувь буюу 39,041 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 59.5 хувь буюу 43,225 гишүүн Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг бол 40.5 хувь буюу 29,426 гишүүн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.


График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт, хот, орон нутгаар



2017-2020 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо тогтмол өссөн байна.

Нийт 249 ХЗХ-ны 46.6 хувь буюу 116 ХЗХ 20-100 гишүүнтэй, 42.6 хувь буюу 106 ХЗХ 101-500 гишүүнтэй, 7.2 хувь буюу 18 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 3.6 хувь буюу 9 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



- 20-100 гишүүнтэй
- 101-500 гишүүнтэй
- 501-1,000 гишүүнтэй
- 1,001-ээс дээш гишүүнтэй

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 9 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 45.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	116	6,519	9.0%
101-500 гишүүнтэй	106	21,382	29.4%
501-1,000 гишүүнтэй	18	11,554	15.9%
1,001-ээс дээш гишүүнтэй	9	33,196	45.7%
Нийт	249	72,651	100.0%

## 1.4 Хууль тогтоомжийн өөрчлөлт

- Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжсэнээс эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэний улмаас санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 122/58 дугаар тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нэмэлт оруулж, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Түр журмын хугацааг Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд буюу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгахаар Хорооны 2020 оны 854 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, улмаар 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгахаар 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1023 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.

- Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-д 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтийн дагуу ХЗХ-дын 2020 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланг шинэчилсэн загвараар хүлээн авсан.

- Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллаж улсын бүртгэлд бүртгүүлсэн боловч тусгай зөвшөөрөл авахаар хандаагүй, хандсан боловч нөхцөл шаардлага хангаагүйн улмаас тусгай зөвшөөрөл олгоогүй, эсхүл тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон 285 хадгаламж, зээлийн хоршооны бүртгэлийг хүчингүй болгосон.

- Хорооны 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, хадгаламж, зээлийн хоршооны салбар байгуулах болон санхүүгийн бусад

ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн хүсэлтийг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хүлээж авахгүй байхаар шийдвэрлэж, тогтоосон хугацаанд гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах, тогтворжилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг урт хугацаанд салбарын тогтвортой хөгжлийг хангах ажилд бэлтгэх, хадгаламж, зээлийн хоршоодын эрсдэлийг тогтоох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

- Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулсан Хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.



Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт зээлдэгч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>249</b>	<b>100.0%</b>	<b>148</b>	<b>59.4%</b>	<b>101</b>	<b>40.6%</b>
<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	167,573,011.08	100.0%	137,263,611.63	81.9%	30,309,399.45	18.1%
<b>Нийт зээлдэгчийн тоо</b>	<b>35,827</b>	<b>100.0%</b>	<b>21,240</b>	<b>59.3%</b>	<b>14,587</b>	<b>40.7%</b>
Иргэн	35,749	99.8%	21,183	99.7%	14,566	99.9%
Хуулийн этгээд	78	0.2%	57	0.3%	21	0.1%
<b>Зээлдэгчдийн насжилт</b>	<b>35,749</b>	<b>100.0%</b>	<b>21,183</b>	<b>59.3%</b>	<b>14,566</b>	<b>40.7%</b>
18-35 насны	14,696	41.1%	11,230	53.0%	3,466	23.8%
36-45 насны	8,665	24.3%	4,054	19.1%	4,611	31.7%
46-55 насны	8,552	23.9%	4,488	21.2%	4,064	27.9%
55-аас дээш	3,836	10.7%	1,411	6.7%	2,425	16.6%
<b>Зээлдэгчдийн боловсрол</b>	<b>35,749</b>	<b>100.0%</b>	<b>21,183</b>	<b>59.3%</b>	<b>14,566</b>	<b>40.7%</b>
Дээд	14,796	41.4%	10,294	48.6%	4,502	30.9%
Тусгай дунд	8,043	22.5%	5,697	26.9%	2,346	16.1%
Бүрэн дунд	9,825	27.5%	4,647	21.9%	5,178	35.5%
Дунд	2,300	6.4%	452	2.1%	1,848	12.7%
Бага	785	2.2%	93	0.4%	692	4.8%

Тайлант улиралд ХЗХ-д 35,827 зээлдэгчийн 167,573,011.08 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Нийт зээлдэгчийн 59.3 хувь буюу 21,240 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд бол 40.7 хувь буюу 14,566 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын 21,240 зээлдэгчийн зээлийн үлдэгдэл нийт зээлийн 81.9 хувь буюу 137,263,611.63 мянган

төгрөгийг бүрдүүлж байна. Орон нутгийн ХЗХ-дын 14,587 зээлдэгчийн зээлийн үлдэгдэл нийт зээлийн 18.1 хувь буюу 30,309,399.45 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.8 хувь буюу 35,827 зээлдэгч нь хувь хүн, 0.2 хувь буюу 78 зээлдэгч нь хуулийн этгээд байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	249	100.0%	148.00	59.4%	101.00	40.6%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	182,183,840.61	100.0%	156,143,645.41	85.7%	26,040,195.20	14.3%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	35,870	100.0%	19,983	55.7%	15,887	44.3%
<b>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>3,013,136.04</b>	<b>1.7%</b>	<b>2,165,526.02</b>	<b>1.4%</b>	<b>847,610.02</b>	<b>3.3%</b>
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	4,436	12.4%	3,516	17.6%	920	5.8%
Иргэн	4,415	12.3%	3,498	17.5%	917	5.8%
Хуулийн этгээд	21	0.1%	18	0.1%	3	0.0%
<b>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>179,170,704.56</b>	<b>98.3%</b>	<b>153,978,119.39</b>	<b>98.6%</b>	<b>25,192,585.17</b>	<b>96.7%</b>
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	31,434	87.6%	16,467	82.4%	14,967	94.2%
Иргэн	31,378	87.5%	16,456	82.3%	14,922	93.9%
Хуулийн этгээд	56	0.2%	11	0.1%	45	0.3%
<b>Хадгаламж эзэмшигчдийн насжилт</b>	<b>35,793</b>	<b>100.0%</b>	<b>19,954</b>	<b>55.7%</b>	<b>15,839</b>	<b>55.7%</b>
18-35 насны	12,812	35.8%	8,596	43.1%	4,216	26.6%
36-45 насны	9,374	26.2%	4,860	24.4%	4,514	28.5%
46-55 насны	7,979	22.3%	3,858	19.3%	4,121	26.0%

55-аас дээш	5,628	15.7%	2,640	13.2%	2,988	18.9%
<b>Хадгаламж эзэмшигчдийн боловсрол</b>	<b>35,793</b>	<b>100.0%</b>	<b>19,954</b>	<b>55.7%</b>	<b>15,839</b>	<b>44.3%</b>
Дээд	17,242	48.2%	12,257	61.4%	4,985	31.5%
Тусгай дунд	5,627	15.7%	2,990	15.0%	2,637	16.6%
Бүрэн дунд	7,621	21.3%	3,349	16.8%	4,272	27.0%
Дунд	3,730	10.4%	966	4.8%	2,764	17.5%
Бага	1,573	4.4%	392	2.0%	1,181	7.5%

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 35,870 хадгаламж эзэмшигчийн 182,183,840.61 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 55.7 хувь буюу 19,893 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байх бөгөөд нийт хадгаламжийн үлдэгдлийн 85.7 хувь буюу 156,143,645.41 мянган төгрөгийн бүрдүүлж байна. Харин орон нутгийн ХЗХ-дын 15,887 хадгаламж эзэмшигч нь нийт

хадгаламж эзэмшигчдийн 44.3 хувийг эзлэх бөгөөд нийт хадгаламжийн үлдэгдлийн 14.3 хувь буюу 26,040,195.20 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 12.4 хувийг хугацаагүй хадгаламжтай, 87.6 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 35,793 нь хувь хүн, 0.2 хувь буюу 77 нь хуулийн этгээд байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны салбарын нийт хөрөнгө 255,974,886.87 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувь буюу 33,358,225.57 мянган төгрөгөөр өсөж банкны салбарын 0.7 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 6.9 хувь буюу 10,885,848.28 мянган төгрөг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 16.9

хувь буюу 26,380,580.31 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Салбарын нийт орлого 4.8 хувь буюу 2,430,818.18 мянган төгрөг, нийт зарлага 5.8 хувь буюу 2,423,893.96 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 0.1 хувь буюу 6,924.21 мянган төгрөгөөр нэмэгдэж 9,174,901.61 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны IV улирал	2020 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	222,616,661.30	255,974,886.87		
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.7%	33,358,225.57	15.0%
<b>Нийт зээл</b>	156,687,162.80	167,573,011.08		
Банкны салбарт эзлэх хувь	0.9%	1.0%	10,885,848.28	6.9%
<b>Нийт чанаргүй зээл</b>	6,152,055.80	7,362,704.72		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.9%	4.4%	0.5%	11.9%
Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.5%	0.0%	5.1%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	155,803,260.30	182,183,840.61		
Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.1%	26,380,580.31	16.9%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	18,014,225.80	18,469,981.60		
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	24,693,258.80	30,742,763.91		
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	9,266,616.60	8,922,819.90		
Нийт орлого	50,634,318.30	53,065,136.48	2,430,818.18	4.8%
Нийт зарлага	41,466,340.90	43,890,234.86	2,423,893.96	5.8%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>9,167,977.40</b>	<b>9,174,901.61</b>	<b>6,924.21</b>	<b>0.1%</b>

## 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 148 ХЗХ-ны нийт хөрөнгө 215,928,793.82 мянган төгрөг нь салбарын 84.4 хувь, нийт зээл 137,263,611.63 мянган төгрөг нь салбарын 81.9 хувь, нийт хадгаламж 156,143,645.41 мянган төгрөг нь салбарын 85.7 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.3 хувь буюу 1,346,431.96 мянган төгрөгөөр нэмэгдэж 6,897,956.36

мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 5.0 хувийг бүрдүүлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 6.1 хувь буюу 553,788.51 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 2.0 хувь буюу 824,865.53 мянган төгрөгөөр, нийт зарлага 2.9 хувь буюу 1,026,615.29 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж цэвэр орлого 2.9 хувь буюу 201,749.76 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны IV улирал	2020 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	192,680,753.80	215,928,793.82	23,248,040.02	12.1%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	86.6%	84.4%	-2.2%	-2.5%
<b>Нийт зээл</b>	132,800,936.60	137,263,611.63	4,462,675.03	3.4%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	84.8%	81.9%	-2.8%	-3.4%
<b>Нийт чанаргүй зээл</b>	5,551,524.40	6,897,956.36	1,346,431.96	24.3%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	90.2%	93.7%	3.4%	3.8%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.2%	5.0%	0.8%	20.2%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	137,944,724.70	156,143,645.41	18,198,920.71	13.2%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	88.5%	85.7%	-2.8%	-3.2%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	12,952,230.60	13,168,060.26	215,829.66	1.7%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	71.9%	71.3%	-0.6%	-0.8%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	19,501,955.60	24,619,202.49	5,117,246.89	26.2%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	79.0%	80.1%	1.1%	1.4%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	9,138,157.30	8,584,368.79	-553,788.51	-6.1%
Нийт орлого	42,173,329.40	42,998,194.93	824,865.53	2.0%
Нийт зарлага	35,190,536.40	36,217,151.69	1,026,615.29	2.9%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>6,982,793.00</b>	<b>6,781,043.24</b>	<b>-201,749.76</b>	<b>-2.9%</b>

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 101 ХЗХ-ны нийт хөрөнгө 40,046,093.05 мянган төгрөг нь салбарын 15.6 хувь, нийт зээлийн үлдэгдэл 30,309,399.45 мянган төгрөг нь салбарын 18.1 хувь, нийт хадгаламж 26,040,195.20 мянган төгрөг нь салбарын 14.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт

орлого өмнөх оны мөн үеэс 19.0 хувь буюу 1,605,952.64 мянган төгрөг, нийт зарлага 22.3 хувь буюу 1,397,278.67 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 9.5 хувь буюу 208,673.97 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,393,858.37 мянган төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны IV улирал	2020 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	29,935,907.50	40,046,093.05	10,110,185.55	33.8%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	13.4%	15.6%	2.2%	16.3%
<b>Нийт зээл</b>	23,886,226.20	30,309,399.45	6,423,173.25	26.9%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	15.2%	18.1%	2.8%	18.6%
<b>Нийт чанаргүй зээл</b>	600,531.40	464,748.36	-135,783.04	-22.6%

ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	9.8%	6.3%	-3.4%	-35.3%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.5%	1.5%	-1.0%	-25.1%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	17,858,535.70	26,040,195.20	8,181,659.50	45.8%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	11.5%	14.3%	2.8%	24.7%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	5,061,995.20	5,301,921.34	239,926.14	4.7%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	28.1%	28.7%	0.6%	2.2%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	5,191,303.20	6,123,561.42	932,258.22	18.0%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	21.0%	19.9%	-1.1%	-5.3%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	128,459.30	338,451.11	209,991.81	163.5%
Нийт орлого	8,460,988.90	10,066,941.54	1,605,952.64	19.0%
Нийт зарлага	6,275,804.50	7,673,083.17	1,397,278.67	22.3%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>2,185,184.40</b>	<b>2,393,858.37</b>	<b>208,673.97</b>	<b>9.5%</b>


## ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2019 оны IV улирал		2020 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>218,368,660.10</b>	<b>98.1%</b>	<b>251,616,752.84</b>	<b>98.3%</b>	<b>33,248,092.74</b>	<b>15.2%</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	<b>57,607,562.50</b>	<b>25.9%</b>	<b>77,670,083.10</b>	<b>30.3%</b>	<b>20,062,520.60</b>	<b>34.8%</b>
Бэлэн мөнгө	2,899,173.90	1.3%	3,476,736.96	1.4%	577,563.06	19.9%
Банкинд байршуулсан харилцах	22,056,662.50	9.9%	51,377,854.62	20.1%	29,321,192.12	132.9%
Банкинд байршуулсан хадгаламж	32,651,726.20	14.7%	22,815,491.52	8.9%	-9,836,234.68	-30.1%
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	<b>0</b>	<b>0.0%</b>	<b>100,000.00</b>	<b>0.0%</b>	<b>100,000.00</b>	
Арилжааны үнэт цаас	0	0.0%	100,000.00	0.0%	100,000.00	
<b>Зээл /цэврээр/</b>	<b>152,188,622.90</b>	<b>68.4%</b>	<b>162,563,225.72</b>	<b>63.5%</b>	<b>10,374,602.82</b>	<b>6.8%</b>
Нийт зээл	156,687,162.80	70.4%	167,573,011.08	65.5%	10,885,848.28	6.9%
Хэвийн зээл	143,253,750.40	64.3%	154,667,866.45	60.4%	11,414,116.05	8.0%
Хугацаа хэтэрсэн зээл	7,281,356.60	3.3%	5,542,439.91	2.2%	-1,738,916.69	-23.9%
Чанаргүй зээл	6,152,055.80	2.8%	7,362,704.72	2.9%	1,210,648.92	19.7%
(Зээлийн эрсдэлийн сан )	4,498,539.90	2.0%	5,009,785.36	2.0%	511,245.46	11.4%
<b>Авлага</b>	<b>6,770,863.40</b>	<b>3.0%</b>	<b>9,376,201.73</b>	<b>3.7%</b>	<b>2,605,338.33</b>	<b>38.5%</b>
Байгууллага, хүмүүсээс авах авлага	1,278,868.10	0.6%	1,784,413.83	0.7%	505,545.73	39.5%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	5,491,995.30	2.5%	7,591,787.90	3.0%	2,099,792.60	38.2%
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	<b>916,368.20</b>	<b>0.4%</b>	<b>869,229.59</b>	<b>0.3%</b>	<b>-47,138.61</b>	<b>-5.1%</b>
<b>Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/</b>	<b>885,242.90</b>	<b>0.4%</b>	<b>1,038,012.71</b>	<b>0.4%</b>	<b>152,769.81</b>	<b>17.3%</b>
Өмчлөх бусад хөрөнгө	1,056,866.10	0.5%	1,061,140.49	0.4%	4,274.39	0.4%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	171,623.10	0.1%	23,127.78	0.0%	-148,495.32	-86.5%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4,248,001.30</b>	<b>1.9%</b>	<b>4,358,134.03</b>	<b>1.7%</b>	<b>110,132.73</b>	<b>2.6%</b>
<b>Үндсэн хөрөнгө /цэвр/</b>	<b>4,015,895.20</b>	<b>1.8%</b>	<b>4,146,230.56</b>	<b>1.6%</b>	<b>130,335.36</b>	<b>3.2%</b>
Үндсэн хөрөнгө	5,317,125.60	2.4%	5,803,107.55	2.3%	485,981.95	9.1%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,301,230.40	0.6%	1,656,877.00	0.6%	355,646.60	27.3%
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>216,486.10</b>	<b>0.1%</b>	<b>196,383.47</b>	<b>0.1%</b>	<b>-20,102.63</b>	<b>-9.3%</b>
Биет бус хөрөнгө	253,385.20	0.1%	263,400.06	0.1%	10,014.86	4.0%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	36,899.10	0.0%	67,016.59	0.0%	30,117.49	81.6%
<b>Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө</b>	<b>15,620.00</b>	<b>0.0%</b>	<b>15,520.00</b>	<b>0.0%</b>	<b>-100.00</b>	<b>-0.6%</b>
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,620.00	0.0%	15,520.00	0.0%	-100.00	-0.6%
<b>Хөрөнгийн дүн</b>	<b>222,616,661.30</b>	<b>100.0%</b>	<b>255,974,886.87</b>	<b>100.0%</b>	<b>33,358,225.57</b>	<b>15.0%</b>

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.9 хувь буюу 10,885,848.28 мянган төгрөгөөр өсөж 167,573,011.08 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,009,785.36 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 162,563,225.72 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хэвийн бус зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.9 хувь буюу 1,738,916.69 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.


ХЗХ-ны салбарын нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2017-2020 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

### 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 3 ХЗХ-ны нийт хөрөнгө 158,302,890.74 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 61.8 хувийг, гишүүдийн тоо 20,201 байгаа нь нийт гишүүдийн 27.8 хувийг тус тус эзэлж байна.


Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүдийн тоо	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	3	158,302,890.74	61.8%	20,201	27.8%
2	1,000,000.0 - 10,000,000.0	19	60,496,689.42	23.6%	20,346	28.0%
3	500,000.0-1,000,000.0	17	12,442,644.31	4.9%	6,566	9.0%
4	100,000.0-500,000.0	85	17,803,079.03	7.0%	15,543	21.4%
5	50,000.0-100,000.0	73	5,502,821.48	2.2%	7,103	9.8%
6	10,000.0-50,000.0	45	1,392,304.82	0.5%	2,728	3.8%
7	10,000.0 хүртэл	7	34,457.07	0.0%	164	0.2%
<b>Нийт дүн</b>		<b>249</b>	<b>255,974,886.87</b>	<b>100.0%</b>	<b>72,651.00</b>	<b>100.0%</b>



2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны салбарын нийт хөрөнгө 255,974,886.87 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувь буюу 33,358,225.57 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Салбарын нийт хөрөнгийн 98.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 30.3 хувийг, цэвэр зээл 63.5 хувийг тус тус эзэлж байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд салбарын нийт зээлийн үлдэгдэл 167,573,011.08 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 65.5 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 162,563,225.72 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 63.5 хувийг тус тус эзэлж байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 19 ХЗХ-ны зээлийн дүн салбарын нийт зээлийн 81.9 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 7 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш 500,000.0-	19	137,288,884.14	81.9%
2	1,000,000.0	11	7,339,533.33	4.4%
3	100,000.0- 500,000.0	72	15,996,660.40	9.6%
4	50,000.0- 100,000.0	71	5,003,822.91	3.0%
5	10,000.0-50,000.0	60	1,890,343.14	1.1%
6	10,000.0 хүртэл	9	53,767.17	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	7	-	-
<b>Нийт дүн</b>			<b>249 167,573,011.08</b>	<b>100%</b>

Хүснэгт 12: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1 Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4,776,544.16	10,741,306.63	9,865,078.23	5,652,122.56	3.4%
2 Уул уурхай, олборлолт	1,493,342.38	2,222,179.66	1,872,153.62	1,843,368.42	1.1%
3 Боловсруулах үйлдвэрлэл	2,089,741.43	2,736,791.55	2,873,037.16	1,962,252.47	1.2%
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	380,167.32	477,443.33	510,039.30	347,571.35	0.2%
5 Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	182,178.06	6,500.00	142,303.36	46,374.71	0.0%
6 Барилга	3,552,440.82	6,281,045.74	5,417,678.21	4,415,808.34	2.6%
7 Бөөний болон жижиглэн худалдаа	15,125,490.77	21,856,653.66	20,672,296.95	16,221,391.94	9.7%
8 Машин мотоциклийн засвар үйлчилгээ	1,078,931.67	1,246,032.21	1,105,167.71	1,219,796.16	0.7%
9 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	395,079.61	458,824.49	547,170.12	306,733.97	0.2%
10 Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2,205,151.68	3,663,875.22	2,640,378.82	3,229,648.08	1.9%
11 Мэдээлэл холбоо	146,654.79	26,696.73	67,930.35	105,421.17	0.1%
12 Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3,970,175.98	6,790,267.50	5,455,320.95	5,305,122.52	3.2%
13 Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2,424,080.41	1,802,704.24	1,994,220.94	2,232,563.72	1.3%
14 Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	566.45	77,000.00	14,108.90	63,457.55	0.0%
15 Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	167,180.87	296,598.00	246,162.53	217,616.34	0.1%
16 Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	-	-	-	-	0.0%
17 Боловсрол	1,540,675.19	1,364,442.60	1,747,892.95	1,157,224.84	0.7%
18 Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	1,162,960.28	1,244,572.46	1,438,267.08	969,265.65	0.6%
19 Бусад	114,331,104.07	329,790,643.23	321,925,279.75	122,277,271.28	73.0%
Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл	19,901,329.08	31,915,209.73	37,063,937.26	14,571,391.93	8.7%
<b>НИЙТ</b>	<b>154,928,020.59</b>	<b>391,083,577.23</b>	<b>378,670,806.52</b>	<b>167,573,011.08</b>	<b>100.0%</b>

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д нийт 391,083,577.23 мянган төгрөгийн зээл олгож, 378,670,806.52 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж

167,573,011.08 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг зээлийн бүтээгдэхүүнээр нь ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 73.0 хувь буюу

122,277,271.28 мянган төгрөгийг бусад, 9.7 хувь буюу 16,221,391.94 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 3.4 хувь буюу 5,652,122.56 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 3.2 хувь буюу 5,305,122.52 мянган төгрөгийг санхүүгийн болон

даатгалын үйл ажиллагаа, 2.6 хувь буюу 4,415,808.34 мянган төгрөгийн барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 8.7 хувь буюу 14,571,391.93 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

### 3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Нийт</b>	<b>35,827</b>	<b>100.0%</b>	<b>167,573,011.08</b>	<b>100.0%</b>
Хэвийн	33,221	92.7%	154,667,866.45	92.3%
Хугацаа хэтэрсэн	1,184	3.3%	5,542,439.91	3.3%
Чанаргүй	1,422	4.0%	7,362,704.72	4.4%
<i>Хэвийн бус</i>	<i>495</i>	<i>34.8%</i>	<i>2,550,717.52</i>	<i>34.6%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>398</i>	<i>28.0%</i>	<i>1,535,645.87</i>	<i>20.9%</i>
<i>Муу</i>	<i>529</i>	<i>37.2%</i>	<i>3,276,341.32</i>	<i>44.5%</i>

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны салбарын хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 92.3 хувь буюу 154,667,866.45 мянган төгрөгийг хэвийн зээл, 3.3 хувь буюу 5,542,439.91 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 4.4 хувь буюу 7,362,704.72 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдлээс бүрдэж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,905,144.63 мянган төгрөгийн үлдэгдэлд 38.8 хувь буюу 5,009,785.36

мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.7 хувийг хэвийн, 3.3 хувийг хугацаа хэтэрсэн, 4.0 хувийг чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,422 зээлдэгчийн 7,362,705 мянган төгрөгийн үлдэгдлийг 34.8 хувийг хэвийн бус, 28.0 хувийг эргэлзээтэй, 37.2 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

График 8: Зээлийн чанар



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр өсөж 92.3 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.3 пунктээр буурч 3.3 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.5 пунктээр өсөж 4.4 хувьд хүрсэн байна.


Хүснэгт 14: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
<b>Нийт</b>	<b>137,263,611.63</b>	<b>100.0%</b>	<b>81.9%</b>	<b>30,309,399.45</b>	<b>100.0%</b>	<b>18.1%</b>
Хэвийн	125,822,148.31	91.7%	88.7%	28,845,718.14	95.2%	19.6%
Хугацаа хэтэрсэн	4,543,506.96	3.3%	82.0%	998,932.95	3.3%	18.0%
Чанаргүй	6,897,956.36	5.0%	93.7%	464,748.36	1.5%	6.3%
<i>Хэвийн бус</i>	<i>2,363,373.47</i>	<i>34.3%</i>	<i>92.7%</i>	<i>187,344.05</i>	<i>40.3%</i>	<i>7.3%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>1,399,755.47</i>	<i>20.3%</i>	<i>91.2%</i>	<i>135,890.40</i>	<i>29.2%</i>	<i>8.8%</i>
<i>Муу</i>	<i>3,134,827.42</i>	<i>45.4%</i>	<i>95.7%</i>	<i>141,514.91</i>	<i>30.4%</i>	<i>4.3%</i>

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны салбарын нийт зээлийн 81.9 хувь буюу 137,263,611.63 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 18.1 хувь буюу 30,309,399.45 мянган төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 91.7 хувь буюу 125,822,148.31 мянган төгрөгийг хэвийн, 3.3 хувь буюу 4,543,506.96 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 5.0 хувь буюу 6,897,956.36 мянган төгрөгийн чанаргүй

зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 45.4 хувь буюу 3,134,827.42 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд салбарын нийт муу зээлийн 95.7 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 95.2 хувь буюу 28,845,718.14 мянган төгрөгийг хэвийн, 3.3 хувь буюу 998,932.95 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 1.5 хувь буюу 464,748.36 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 9: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



## ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар


Хүснэгт 15: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)

ЭХ ҮҮСВЭР	2019 IV улирал		2020 IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Өр төлбөр</b>	<b>179,749,246.00</b>	<b>80.7%</b>	<b>206,503,733.55</b>	<b>80.7%</b>	<b>26,754,487.55</b>	<b>14.9%</b>
Хадгаламж	155,803,260.30	70.0%	182,183,840.61	71.2%	26,380,580.31	16.9%
Хугацаагүй	2,623,906.40	1.2%	3,013,136.04	1.2%	389,229.64	14.8%
Хугацаатай	153,179,353.90	68.8%	179,170,704.56	70.0%	25,991,350.66	17.0%
<b>Богино хугацаат зээл</b>	<b>3,776,434.50</b>	<b>1.7%</b>	<b>3,012,830.61</b>	<b>1.2%</b>	<b>-763,603.89</b>	<b>-20.2%</b>
<b>Бусад богино хугацаат өр төлбөр</b>	<b>14,665,837.60</b>	<b>6.6%</b>	<b>15,379,024.39</b>	<b>6.0%</b>	<b>713,186.79</b>	<b>4.9%</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>5,503,713.60</b>	<b>2.5%</b>	<b>5,928,037.95</b>	<b>2.3%</b>	<b>424,324.35</b>	<b>7.7%</b>
<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>42,867,415.30</b>	<b>19.3%</b>	<b>49,471,153.32</b>	<b>19.3%</b>	<b>6,603,738.02</b>	<b>15.4%</b>
<b>Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>18,014,225.80</b>	<b>8.1%</b>	<b>18,469,981.60</b>	<b>7.2%</b>	<b>455,755.80</b>	<b>2.5%</b>
Гишүүний оруулсан хувь хөрөнгө	17,893,210.00	8.0%	18,338,851.88	7.2%	445,641.88	2.5%
Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	121,015.80	0.1%	131,129.71	0.1%	10,113.91	8.4%
<b>Дахин үнэлгээний нэмэгдэл</b>	<b>159,930.80</b>	<b>0.1%</b>	<b>258,407.82</b>	<b>0.1%</b>	<b>98,477.02</b>	<b>61.6%</b>
<b>Хоршоологчдын өмч</b>	<b>24,693,258.80</b>	<b>11.1%</b>	<b>30,742,763.91</b>	<b>12.0%</b>	<b>6,049,505.11</b>	<b>24.5%</b>
Нөөцийн сан	4,432,844.30	2.0%	8,147,678.98	3.2%	3,714,834.68	83.8%
Хандив, тусламж	524,538.20	0.2%	524,007.25	0.2%	-530.95	-0.1%
Хадгаламж, хамгаалалтын сан	1,493,753.80	0.7%	1,912,116.47	0.7%	418,362.67	28.0%
Нийгмийн хөгжлийн сан	595,804.20	0.3%	749,111.79	0.3%	153,307.59	25.7%

Тогтворжилтын сан	1,484,438.70	0.7%	1,909,446.65	0.7%	425,007.95	28.6%
Бусад сангууд	1,018,307.70	0.5%	1,338,561.72	0.5%	320,254.02	31.4%
Хуримтлагдсан орлого /алдагдал/	15,143,571.80	6.8%	16,161,841.05	6.3%	1,018,269.25	6.7%
Тайлангийн үеийн цэвэр орлого	9,167,977.40	4.1%	9,174,901.61	3.6%	6,924.21	0.1%
Өмнөх үеийн цэвэр орлого	5,975,594.50	2.7%	6,986,939.44	2.7%	1,011,344.94	16.9%
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>222,616,661.30</b>	<b>100.0%</b>	<b>255,974,886.87</b>	<b>100.0%</b>	<b>33,358,225.57</b>	<b>15.0%</b>

Салбарын нийт өр төлбөр 206,503,733.55 мянган төгрөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.9 хувь буюу 26,754,487.55 мянган төгрөгөөр, өөрийн хөрөнгө 49,471,153.32 мянган төгрөг нь 15.4 хувь буюу 6,603,738.02 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн бүтцийн 80.7 хувийг өр төлбөр, 19.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

График 10: Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



ХЗХ-дын хоршоологчдын өмчийн хэмжээ 2016 оны 4 дүгээр улиралд 12,119,877.04 мянган төгрөг байсан бол 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 154.1 хувь буюу 18,622,886.87 мянган төгрөгөөр өсөж 30,742,763.91 мянган төгрөгт хүрсэн. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 2016 оны мөн үед 68,149,279.46 мянган төгрөг байсан бол 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 167.5 хувь буюу 114,034,561.14 мянган төгрөгөөр өсөж 182,183,840.61 мянган төгрөгт хүрсэн байна.

#### 4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар


Салбарын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 182,183,840.61 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 71.2 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн 98.3 хувийг хугацаатай хадгаламж, 1.7 хувийг хугацаагүй хадгаламж тус тус бүрдүүлж байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүнгээр 10 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжтай 3 ХЗХ-ны хадгаламж нийт ХЗХ-дын хадгаламжийн дүнгийн 66.3 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 13 ХЗХ хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 16: ХЗХ-дын хадгаламж, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хадгаламжийн хэмжээ	ХЗХ-д	Хадгаламжийн дүн	Эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	3	120,861,880.38	66.4%
2	1,000,000.0-10,000,000.0	16	41,154,661.69	22.6%
3	500,000.0-1,000,000.0	7	4,623,261.975	2.5%
4	100,000.0-500,000.0	49	11,475,842.48	6.3%
5	50,000.0-100,000.0	24	1,744,571.95	1.0%
6	10,000.0-50,000.0	85	2,059,107.93	1.1%
7	5,000.0-10,000.0	26	194,497.16	0.1%
8	5,000.0 хүртэл	26	70,017.05	0.0%
9	Хадгаламжгүй	13	-	-
<b>Нийт дүн</b>		<b>249</b>	<b>182,183,840.61</b>	<b>100%</b>

График 11: ХЗХ-ны салбарын хадгаламжийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



Салбарын хэмжээнд нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар 16.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### 4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар

Хүснэгт 17: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц (мянган төгрөгөөр)

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	2019 IV улирал		2020 IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Богино хугацаат зээл</b>	<b>3,776,434.53</b>	<b>40.7%</b>	<b>3,012,830.61</b>	<b>33.7%</b>	<b>-763,603.92</b>	<b>-20.2%</b>
Банкнаас авсан зээл	1,093,851.50	11.8%	125,750.50	1.4%	-968,101.00	-88.5%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	490,271.34	5.3%	607,125.22	6.8%	116,853.88	23.8%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	2,192,311.70	23.6%	2,279,954.89	25.5%	87,643.19	4.0%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>5,503,713.55</b>	<b>59.3%</b>	<b>5,928,037.95</b>	<b>66.3%</b>	<b>424,324.40</b>	<b>7.7%</b>
Банкнаас авсан зээл	613.80	0.0%	0	0.0%	-613.80	-100.0%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	412,795.55	4.4%	2,299,095.16	25.7%	1,886,299.61	457.0%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	5,076,772.72	54.7%	3,610,894.14	40.4%	-1,465,878.58	-28.9%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	13,531.48	0.1%	18,048.66	0.2%	4,517.17	33.4%
<b>Нийт дүн</b>	<b>9,280,148.08</b>	<b>100.0%</b>	<b>8,940,868.56</b>	<b>100.0%</b>	<b>-339,279.52</b>	<b>-3.7%</b>

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын бусдаас авсан зээлийн үлдэгдэл 8,940,868.56 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 3.5 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 хувь буюу 339,279.52 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант улиралд бусдаас авсан нийт зээлийн 33.7 хувийг богино

хугацаат зээл, 66.3 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Богино хугацаат зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20.2 хувь буюу 763,603.92 мянган төгрөгөөр буурч, урт хугацаат өр төлбөр 7.7 хувь буюу 424,324.40 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 18: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц, хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	Нийт		УБ		Орон нутаг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Банкнаас авсан зээл	125,750.50	1.4%	0.00	0.0%	125,750.50	37.2%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	2,906,220.38	32.6%	2,774,095.16	32.3%	132,125.22	39.0%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	5,890,849.02	66.0%	5,810,273.63	67.7%	80,575.39	23.8%
<b>Нийт дүн</b>	<b>8,922,819.90</b>	<b>100%</b>	<b>8,584,368.79</b>	<b>100%</b>	<b>338,451.11</b>	<b>100%</b>

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 1.4 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 32.6 хувь, төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 66.0 хувийг тус тус эзэлж байна.

#### 4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар

Хүснэгт 19: ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөрийн бүтэц /мянган төгрөгөөр/

БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2019 IV улирал		2020 IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Цалингийн өглөг	81,553.06	0.6%	125,558.43	0.8%	44,005.37	54.0%
Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	821,453.46	5.6%	1,003,517.46	6.5%	182,063.99	22.2%
Ногдол ашгийн өглөг	71,233.52	0.5%	144,443.72	0.9%	73,210.20	102.8%
Санхүүгийн түрээсийн өглөг	652.5	0.0%	0	0.0%	-652.50	-100.0%
Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	0	0.0%	0	0.0%	0.00	0.0%
Урьдчилж орсон орлого	116,122.71	0.8%	64,135.31	0.4%	-51,987.39	-44.8%
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	12,035,765.75	82.1%	12,601,044.30	81.9%	565,278.55	4.7%
Салбар хоорондын тооцоогоорх өглөг	1785.53125	0.0%	0	0.0%	-1,785.53	-100.0%
Бусад богино хугацаат өглөг	1,537,271.02	10.5%	1,440,325.16	9.4%	-96,945.86	-6.3%
<b>Нийт дүн</b>	<b>14,665,837.56</b>	<b>100.0%</b>	<b>15,379,024.39</b>	<b>100.0%</b>	<b>713,186.83</b>	<b>4.9%</b>

Тайлант улиралд ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөр 15,379,024.39 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 713,186.83 мянган төгрөг буюу 4.9 хувиар өсөж салбарын нийт хөрөнгийн 6.0 хувийг эзэлж байна.

#### 4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 18,469,981.60 мянган төгрөг нь нийт эх үүсвэрийн 7.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 20: ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо		Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн	
			Дүн	Хувь	Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	19,073	26.3%	4,681,256.66	25.3%
2	500,000.0-1,000,000.0	5	3,592	4.9%	3220163.79	17.4%
3	100,000.0-500,000.0	28	20,412	28.1%	5,959,399.31	32.3%
4	50,000.0-100,000.0	21	6,522	9.0%	1,402,411.01	7.6%
5	10,000.0-50,000.0	110	16,933	23.3%	2,702,656.17	14.6%
6	5,000.0-10,000.0	58	4,871	6.7%	422,382.92	2.3%
7	5,000.0 хүртэл	25	1,248	1.7%	81,711.73	0.4%
<b>Нийт дүн</b>		<b>249</b>	<b>72,651</b>	<b>100%</b>	<b>18,469,981.60</b>	<b>100%</b>

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө 100 сая төгрөгөөс дээш 35 ХЗХ

↓

Салбарын гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн 75.0%

↓

Нийт гишүүдийн 59.3%

#### 4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 49,471,153.32 мянган төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 12.0 хувийг эзэлж байна.

Тайлант улиралд 14 ХЗХ-ны нийт өр төлбөрийн хэмжээ нь нийт хөрөнгөөс хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон байна.

Хүснэгт 21: ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	5	28,087,200.61	56.8%
2	500,000.0-1,000,000.0	11	7865215.471	15.9%
3	100,000.0-500,000.0	36	7,764,907.44	15.7%
4	50,000.0-100,000.0	48	3,287,135.51	6.6%
5	10,000.0-50,000.0	95	2,384,336.03	4.8%
6	10,000.0 доош	40	146,859.25	0.3%
7	Өөрийн хөрөнгөгүй	14	-64,500.99	-0.1%
<b>Нийт дүн</b>		<b>249</b>	<b>49,471,153.32</b>	<b>100%</b>

Хүснэгт 22: ХЗХ-дын хоршоологчдын өмч, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	3	20,504,109.36	66.7%
2	500,000.0-1,000,000.0	2	1,382,807.41	4.5%
3	100,000.0-500,000.0	24	5,654,280.04	18.4%
4	50,000.0-100,000.0	20	1,426,916.16	4.6%
5	10,000.0-50,000.0	78	1,863,723.58	6.1%
6	5,000.0-10,000.0	27	200,355.68	0.7%
7	1,000.0-5,000.0	36	108,245.75	0.4%
8	1,000.0 хүртэл	10	6,005.52	0.02%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	49	-403,679.60	-1.3%
<b>Нийт дүн</b>		<b>249</b>	<b>30,742,763.91</b>	<b>100%</b>

Тайлант улиралд 49 ХЗХ алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 ХЗХ буюу 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

## ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 5.1 ХЗХ-дын орлогын талаар

Тайлант улиралд салбарын нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8 хувь буюу 2,430,818.18 мянган төгрөгөөр нэмэгдэж 53,065,136.48 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 95.2 хувь хүүгийн орлого, 1.9 хувь үйл ажиллагааны

бусад орлого, 2.9 хувь үйл ажиллагааны бус орлого тус тус бүрдүүлж байна.

Зээлийн хүүгийн орлого 48,814,227.01 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.9 хувь буюу 2,289,873.81 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 23: ХЗХ-дын орлогын бүтэц (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2019.IV		2020.IV		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1. Хүүгийн орлого</b>	<b>48,440,132.50</b>	<b>95.7%</b>	<b>50,515,142.46</b>	<b>95.2%</b>	<b>2,075,009.96</b>	<b>4.3%</b>
Зээлийн хүүгийн орлого	46,524,353.20	91.9%	48,814,227.01	92.0%	2,289,873.81	4.9%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	337,757.90	0.7%	252,697.95	0.5%	-85,059.95	-25.2%
Үнэт цаасны хүүгийн орлого	0	0.0%	0	0.0%	0.00	0.0%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	1,847,213.80	3.6%	1,600,415.77	3.0%	-246,798.03	-13.4%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	1,258.30	0.0%	16,997.24	0.0%	15,738.94	1250.8%
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	270,450.60	0.5%	169,195.52	0.3%	-101,255.08	-37.4%
<b>2. Үйл ажиллагааны бусад орлого</b>	<b>992,664.90</b>	<b>2.0%</b>	<b>1,016,329.54</b>	<b>1.9%</b>	<b>23,664.64</b>	<b>2.4%</b>
<b>3. Үйл ажиллагааны бус орлого</b>	<b>1,201,520.90</b>	<b>2.4%</b>	<b>1,533,664.48</b>	<b>2.9%</b>	<b>332,143.58</b>	<b>27.6%</b>
<b>Нийт орлого</b>	<b>50,634,318.30</b>	<b>100.0%</b>	<b>53,065,136.48</b>	<b>100.0%</b>	<b>2,430,818.18</b>	<b>4.8%</b>

### 5.2 ХЗХ-дын зардлын талаар

Салбарын нийт зардлын хэмжээ 43,890,234.86 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8 хувь буюу 2,423,893.96 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 66.7 хувь, үйл ажиллагааны зардал 26.3 хувь, болзошгүй эрсдэлийн

сангийн зардал 4.7 хувь, үйл ажиллагааны бус зардал 0.3 хувиар тус тус эзэлж байна. Хүүгийн зардал 28,812,258.22 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувь буюу 2,074,559.92 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 24: ХЗХ-дын зардлын бүтэц /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2019.IV		2020.IV		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1.Хүүгийн зардал</b>	<b>27,023,986.20</b>	<b>65.2%</b>	<b>29,285,342.04</b>	<b>66.7%</b>	<b>2,261,355.84</b>	<b>8.4%</b>
Хадгаламжийн хүүгийн зардал	26,737,698.30	64.5%	28,812,258.22	65.6%	2,074,559.92	7.8%

Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	247,997.70	0.6%	443,063.94	1.0%	195,066.24	78.7%
Санхүүгийн гүрээсийн хүүгийн зардал	4,412.80	0.0%	0	0.0%	-4,412.80	-100.0%
Бусад хүүгийн зардал	56,898.10	0.1%	60,931.40	0.1%	4,033.30	7.1%
(Хүүгийн зардлын буцаалт)	23,020.70	0.1%	30,911.52	0.1%	7,890.82	34.3%
<b>2. Болзошгүй эрсдэлийн сангийн зардал</b>	<b>2,107,079.30</b>	<b>5.1%</b>	<b>2,059,380.18</b>	<b>4.7%</b>	<b>-47,699.12</b>	<b>-2.3%</b>
Зээлийн эрсдэлийн зардал	2,095,826.30	5.1%	2,376,267.15	5.4%	280,440.85	13.4%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	120,434.00	0.3%	26,607.27	0.1%	-93,826.73	-77.9%
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	109,181.10	0.3%	343,494.25	0.8%	234,313.15	214.6%
<b>3. Үйл ажиллагааны зардал</b>	<b>11,133,973.40</b>	<b>26.9%</b>	<b>11,540,389.71</b>	<b>26.3%</b>	<b>406,416.31</b>	<b>3.7%</b>
Боловсон хүчний зардал	7,318,229.40	17.6%	7,368,513.50	16.8%	50,284.10	0.7%
Бусад төрлийн зардал	14,949,717.50	36.1%	4,171,876.21	9.5%	-10,777,841.29	-72.1%
<b>4. Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>95,932.00</b>	<b>0.2%</b>	<b>141,551.13</b>	<b>0.3%</b>	<b>45,619.13</b>	<b>47.6%</b>
Татварын зардал	1,105,370.00	2.7%	863,571.80	2.0%	-241,798.20	-21.9%
<b>Нийт зардал</b>	<b>41,466,340.90</b>	<b>100.0%</b>	<b>43,890,234.86</b>	<b>100.0%</b>	<b>2,423,893.96</b>	<b>5.8%</b>
<b>Цэвэр орлого</b>	<b>9,167,977.40</b>	<b>0.0%</b>	<b>9,174,901.61</b>	<b>0.0%</b>	<b>6,924.21</b>	<b>0.1%</b>


### 5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны салбарын цэвэр орлого 9,174,901.61 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувь буюу 6,924.21 мянган төгрөгөөр өссөн байна.

Салбарын нийт орлого сүүлийн 5 жилийн 4 дүгээр улирлын байдлаар тогтмол өссөн байна.

График 12: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/

Зураг 6: Ашигт ажиллагааны зарим үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/



### 5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

Хүснэгт 25: ХЗХ-дын цэвэр орлого, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Ашгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн өгөөж
1	100,000.0 дээш	12	7,946,826.50	80.5%	169,175,664.83	4.7%
2	50,000.0-100,000.0	10	685,240.15	6.9%	22,677,631.41	3.0%
3	10,000.0-50,000.0	42	926,367.89	9.4%	29,857,456.50	3.1%
4	5,000.0-10,000.0	27	193,271.61	2.0%	7,999,506.00	2.4%
5	1,000.0-5,000.0	42	102,013.28	1.0%	3,425,332.93	3.0%
6	1,000.0 хүртэл	42	16,061.92	0.2%	3,543,810.06	0.5%
<b>Нийт дүн</b>		<b>175</b>	<b>9,869,781.36</b>	<b>100%</b>	<b>236,679,401.74</b>	<b>4.2%</b>



2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 249 ХЗХ-ны 70.3 хувь буюу 175 ХЗХ 9,869,781.36 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. 100.0 сая төгрөгөөс дээш ашигтай ажилласан 12 ХЗХ-ны ашиг салбарын нийт ашгийн 80.5 хувийг эзэлж, ашигтай ажилласан ХЗХ-дын хөрөнгийн өгөөж дунджаар 3.8 хувь, салбарын нийт хөрөнгийн өгөөж дунджаар 3.6 хувь байна.

### 5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 249 ХЗХ-ны 26.5 хувь буюу 66 ХЗХ нь 694,879.74 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 ХЗХ буюу 6.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 26: ХЗХ-дын алдагдал, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Алдагдлын хэмжээ	ХЗХ-дын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	10,000.0 дээш	13	-531,427.44	76.5%
2	5,000.0-10,000.0 хүртэл	14	-100,542.92	14.5%
3	1,000.0-5,000.0 хүртэл	25	-57,867.18	8.3%
4	1,000.0 хүртэл	14	-5,042.20	0.7%
<b>Нийт дүн</b>		<b>66</b>	<b>-694,879.74</b>	<b>100.0%</b>

Тайлант улиралд 10 сая төгрөгөөс дээш хэмжээний алдагдалтай ажилласан 13 ХЗХ-ны алдагдал 531,427.44 мянган төгрөг нь нийт алдагдлын 76.5 хувийг эзэлж байна.

## ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2020 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан /2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1022 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/ “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ээр тооцоход дараах байдалтай байна.

### 6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 27: ХЗХ-дын шалгуур үзүүлэлт хангасан байдал

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
<b>Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт</b>				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	-56,282.55 мян.төг	12	4.8%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	44	17.7%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	43	17.3%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	2	0.8%
<b>Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт</b>				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	80	32.1%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	12	4.8%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	74	29.7%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	65	26.1%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	4	1.6%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	82	32.9%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	137	55.0%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	41	16.5%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	40	16.1%
<b>Зардлын зохистой хэмжээ</b>				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	74	29.7%
<b>Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар</b>				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	4%-аас доошгүй	74	29.7%
<b>Өгөөж, зардлын хувь хэмжээ</b>				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			3.6%

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 4.8 хувь буюу 12 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 56,282.55 мянган төгрөгөөр дутуу байгуулж ажилласан байна. Нийт ХЗХ-дын 17.7 хувь буюу 44 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 32.1 хувь буюу 80 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 29.7 хувь буюу 74 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 26.1 хувь буюу 65 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 32.9 хувь буюу 82 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 29.7 хувь буюу 74 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХЗХ-ны салбарын хөрөнгийн өгөөж 3.6 хувь байна.

Тайлант улиралд хангаж ажиллаагүй тохиолдолд Хорооноос тухайн ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлэх хөрөнгө, эх үүсвэрийн 6 зохистой харьцааг ХЗХ-дын 32.5 хувь буюу 81 ХЗХ бүрэн хангаж ажилласан байна.

Хүснэгт 28: Эх үүсвэрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	ХЗХ-дын тоо	Хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	81	32.5%
2	1 ЗХШҮ хангаагүй	66	26.5%
3	2 ЗХШҮ хангаагүй	39	15.7%
4	3 ЗХШҮ хангаагүй	40	16.1%
5	4 ЗХШҮ хангаагүй	21	8.4%
6	5 ЗХШҮ хангаагүй	2	0.8%
<b>Нийт дүн</b>		<b>249</b>	<b>100.0%</b>

## 6.2 Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 29: Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
<b>Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт</b>				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	-42,849.65 мян.төг	7	4.7%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	36	24.3%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	36	24.3%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	2	1.4%
<b>Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт</b>				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	53	35.8%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	3	2.0%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	55	37.2%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	63	42.6%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	4	2.7%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	66	44.6%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	81	54.7%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	15	10.1%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	17	11.5%
<b>Зардлын зохистой хэмжээ</b>				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	59	39.9%
<b>Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар</b>				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	4%-аас доошгүй	53	35.8%
<b>Өгөөж, зардлын хувь хэмжээ</b>				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			3.1%

2020 оны 4 дүгээр улиралд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 148 ХЗХ-ны 8.8 хувь буюу 7 ХЗХ зээлийн

эрсдэлийн санг 42,849.65 мянган төгрөгөөр дутуу байгуулж ажилласан байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын 24.3 хувь

буюу 36 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 35.8 хувь буюу 53 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 37.2 хувь буюу 55 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 42.6 хувь буюу 63 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 44.6 хувь буюу 66 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 39.9 хувь буюу 59 ХЗХ үйл ажиллагааны

зардлын зохистой харьцаа, 35.8 хувь буюу 53 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа ХЗХ-дын хөрөнгийн өгөөж 3.1 хувь байна.

### 6.3 Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 30: Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
<b>Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт</b>				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	-13,432.90 мян.төг	5	5.0%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	8	7.9%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	7	6.9%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	0	0.0%
<b>Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт</b>				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	27	26.7%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	9	8.9%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	19	18.8%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	2	2.0%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	0	0.0%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	16	15.8%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	56	55.4%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	26	25.7%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	23	22.8%
<b>Зардлын зохистой хэмжээ</b>				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	15	14.9%
<b>Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар</b>				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	4%-аас доошгүй	21	20.8%
<b>Өгөөж, зардлын хувь хэмжээ</b>				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			6.0%

Тайлант улиралд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 101 ХЗХ-ны 10.9 хувь буюу 5 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 13,432.90 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна. Орон нутгийн ХЗХ-дын 7.9 хувь буюу 8 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцааг, 26.7 хувь буюу 27 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 18.8 хувь 19 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 2.0 хувь буюу 2 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцааг, 15.8 хувь буюу 16 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг,

14.9 хувь буюу 15 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцааг, 20.8 хувь буюу 21 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа ХЗХ-дын хөрөнгийн өгөөж 6.0 хувь байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 249 ХЗХ хамрагдсанаас 16 ХЗХ өмнөх улирлын тайлангаар, 3 ХЗХ эхлэлтийн тайлангаар нэгтгэсэн болно.

- ХЗХ-дын статистик үзүүлэлт

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 249 ХЗХ 61 салбар, 841 ажилтантай, 72,651 гишүүн /72,439 иргэн, 212 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт 249 ХЗХ-ны эрхэлж буй санхүүгийн бусад ажил үйлчилгээг авч үзвэл тайлант хугацаанд 36.1 хувь буюу 90 ХЗХ төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх, 1.2 хувь буюу 3 ХЗХ санхүүгийн түрээсийн үйлчилгээ, 2.0 хувь буюу 5 ХЗХ даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.4 хувь буюу 1,683 гишүүнээр нэмэгдэж 72,651 гишүүнтэй болсон байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн тоо 43,225 буюу нийт гишүүдийн 59.5 хувь, орон нутгийн ХЗХ-дын гишүүдийн тоо 29,426 буюу нийт гишүүдийн 40.5 хувийг эзэлж байна.

Нийт ХЗХ-дын 35.7 хувь буюу 89 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 ХЗХ буюу 14.1 хувиар нэмэгдсэн байна.

- Салбарын санхүүгийн үзүүлэлт

Салбарын нийт хөрөнгө 255,974,886.87 мянган төгрөг нь банкны салбарын 0.7 хувь, нийт зээл 167,573,011.08 мянган төгрөг нь банкны салбарын 1.0 хувь, чанаргүй зээл 7,362,704.72 мянган төгрөг нь банкны салбарын 0.5 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 182,183,840.61 мянган төгрөг нь банкны салбарын 1.1 хувийг тус тус эзэлж байна.

ХЗХ-дын гишүүдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 18,469,981.60 мянган төгрөг нь

салбарын нийт хөрөнгийн 7.2 хувь, хоршоологчдын өмч 30,742,763.91 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 12.0 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд 53,065,136.48 мянган төгрөгийн орлого, 43,890,234.86 мянган төгрөгийн зардал, 9,174,901.61 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна. Цэвэр орлогын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувь буюу 6,924.21 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-дын нийт хөрөнгө 2015-2019 онуудад жилд дунджаар 23.3 хувь буюу 31,229,606.89 мянган төгрөгийн өсөлттэй байсан бол хадгаламжийн хэмжээ 28.3 хувь буюу 24,135,243.39 мянган төгрөг, зээлийн үлдэгдэл 20.2 хувь буюу 20,337,005.54 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Коронавируст цар тахал гарснаас хойш буюу 2020 оны 4 дүгээр улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хөрөнгө 15.0 хувь буюу 33,358,225.56 мянган төгрөгөөр, нийт хадгаламжийн хэмжээ 16.9 хувь буюу 26,380,580.28 мянган төгрөгөөр, нийт зээлийн үлдэгдэл 6.9 хувь буюу 10,885,848.28 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

- Хөрөнгийн бүтэц, зээлийн үйл ажиллагаа

Тайлант улиралд цэвэр зээлийн үлдэгдэл 162,563,225.72 мянган төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 63.5 хувийг бүрдүүлж байна.

ХЗХ-ны салбарын нийт хөрөнгөд хэвийн зээлийн үлдэгдэл 154,667,866.45 мянган төгрөг нь 60.4 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 5,542,439.91 мянган төгрөг нь 2.2 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 7,362,704.72 мянган төгрөг нь 2.9 хувийг тус тус эзэлж байна. ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,210,648.92 мянган төгрөг буюу 19.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

ХЗХ-дын нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгийн 71.2 хувь буюу 182,183,840.61 мянган төгрөгийг хадгаламж, 9.5 хувь буюу 24,319,892.95 мянган төгрөгийг урт, богино хугацаат өр төлбөр, 7.2 хувь буюу 18,469,981.60 мянган төгрөгийг гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, 12.0 хувь буюу 30,742,763.91 мянган төгрөгийг хоршоологчдын өмч тус тус бүрдүүлж байна.

ХЗХ-дын гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн 98.3 хувь буюу 179,170,704.56 мянган төгрөгийг хугацаатай хадгаламж, 1.7 хувь буюу 3,013,136.04 мянган төгрөгийг хугацаагүй хадгаламж эзэлж байна.

- Орлого, зарлага

Тайлант хугацаанд ХЗХ-ны салбарын нийт орлогын 95.2 хувь буюу 50,515,142.46 мянган төгрөгийг хүүгийн орлого, 1.9 хувь буюу 1,016,329.54 мянган төгрөгийг үйл ажиллагааны бусад орлого, 2.9 хувь буюу 1,533,664.48 мянган төгрөгийг үйл ажиллагааны бус орлого, нийт зардлын 66.7 хувь буюу 29,285,342.04 мянган төгрөгийг хүүгийн зардал, 26.3 хувь буюу 11,540,389.71 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардал тус тус бүрдүүлж байна. Салбарын хэмжээнд цэвэр орлого 9,174,901.61 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувь буюу 6,924.21 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт боловч ХЗХ-дын 26.5 хувь буюу 66 ХЗХ 694,879.74 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ХЗХ-дын 32.5 хувь буюу 81 ХЗХ бүрэн

хангаж ажилласан бөгөөд 32.1 хувь буюу 80 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 32.9 хувь буюу 82 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 29.7 хувь буюу 74 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. ХЗХ-ны салбарын хөрөнгийн өгөөж 3.6 хувь байна.